

ӨМНӨХ ҮГ

Техник технологийн хурдтай өөрчлөлт, хөгжлийн үр дүнд өргөн нэвтрүүлгийн салбар өргөжин тэлж, төрөл бүрийн үйлчилгээ шинэ тутам гарч байгаа өнөө үед өргөн нэвтрүүлгийн үйлчилгээтэй холбоотой нэр томъёо, тодорхойлолт хууль эрх зүйн баримт бичгүүдэд тусаагүй, нэр томъёо тодорхойлолт тодорхой бус байгаагаас зарим гадаад үгийг шууд ашиглах зэргээр олон ялгаатай үг хэллэгүүд өргөн нэвтрүүлгийн салбарт хэрэглэгдэж байна.

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2015 оны 15-р тогтоолоор шинэчлэн баталсан “Өргөн нэвтрүүлгийн зохицуулалт, нөхцөл шаардлага”-д зарим нэр томъёоны тайлбарыг тусгаж өгсөн хэдий ч энэ нь зөвхөн тухайн нөхцөл шаардлагаар зохицуулагдах харилцаатай холбоотой нэр томъёогоор хязгаарлагдаж байдаг.

Стандартын төслийг боловсруулахад өргөн нэвтрүүлгийн салбарт мөрдөгдөж буй хууль, зохицуулалтын баримт бичиг, нөхцөл шаардлага, стандартуудад нийцүүлэхийн зэрэгцээ АНУ, Канад, Их Британи, Австрали, Герман, ОХУ, Украин, Гүрж, Солонгос, Сингапур улсуудын өргөн нэвтрүүлгийн зохицуулалт, баримт бичгүүдэд ашиглаж буй нэр томъёог судлан үзэж, зарим үг хэллэгээс авч ашигласан.

Түүнчлэн радио, телевизийн чиглэлээр хэвлэгдэн гарсан тайлбар толь, ном сурах бичгүүдийг судлан Судлаач Х. Наранжаргалын “Телевизийн сэтгүүл зүй, үндсэн ойлголт, зөвлөмж” ном, Монгол Улсын Их сургуулийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхим, тус тэнхимийн багш эрдэмтэд радио, телевизийн болон сэтгүүл зүйн үйл ажиллагаатай холбогдол бүхий хэд хэдэн ном, тайлбар толь хэвлүүлэн гаргасанаас “Телевизийн тухай А-Я хүртэл”, “Радиоогийн тухай А-Я хүртэл”, “Сэтгүүл зүйн тайлбар толь”, “Телевизийн сэтгүүл зүй, түүх, онол практик” номуудаас зарим үг хэллэгийг авч ашигласан.

Сэтгүүл зүйн чиглэлийн үг хэллэгүүд, тэдгээрийн тайлбар тодорхойлолт нь онолын нарийн агуулга, утга учиртайн дээр Монгол хэл дээр мэргэжлийн ном товхимолууд гарсан байдаг, мөн өргөн нэвтрүүлгийн байгууллагын дотоод үйл ажиллагаад ашиглагддаг үг хэллэг нь нэгэнт тогтож хэвшсэн, зохицуулалтын үйл ажиллагаанд төдийлөн хэрэглэгдэх шаардлагагүй гэж үзээд тэдгээр үг хэллэгийг энэхүү стандартад оруулаагүй болно. Харин **өргөн нэвтрүүлгийн бодлого зохицуулалтын үйл ажиллагаа, хэрэглэгчийн болон зар сурталчилгааны үйлчилгээнд шинээр нэвтэрсэн болон хамгийн түгээмэл хэрэглэгдэж байгаа үг хэллэгүүдийг нэгтгэн томъёолох зарчим баримталсан.**

Өргөн нэвтрүүлгийн сүлжээ, техник, технологитой холбоотой нэр томъёо нь тусдаа стандартаар тодорхойлогдож байгаа болно.

Энэ стандартыг цаашид онлайн хэлбэрт хөгжүүлэх, мөн 2 жил тутамд шинэчлэн баяжуулж байх нь зүйтэй.

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код:.....

Өргөн нэвтрүүлгийн нэр томъёоны стандарт – Үйлчилгээ	MNS-.....
Broadcast Terminology Standards – Services	

Стандартчиллын үндэсний зөвлөлийн 20... оны ... дугаар сарын ...-ны өдрийн ... дугаар тогтоолоор батлав.

Энэ стандарт нь 20... оны ... дугаар сарын ...-ны өдрөөс эхлэн хүчинтэй.

1. Хамрах хүрээ

Энэхүү стандартаар радио, телевизийн өргөн нэвтрүүлгийн зохицуулалт, үйлчилгээ, нэвтрүүлэг, зар сурталчилгаатай холбоотой болон үйл ажиллагааны зарим ерөнхий нэр томъёог тодорхойлно.

2.Нэр томъёо

2.1. Өргөн нэвтрүүлгийн зохицуулалт, үйлчилгээтэй холбоотой нэр томъёо

№	Нэр томъёо	Англи үг	Тайлбар
1.	АйПитВ	IPTV	Телевизийн олон суваг, интернэт, яриа, видео сан, ухраах, нөхөх үйлчилгээг нийтийн интернэтийн сүлжээнээс тусдаа шилэн кабелийн сүлжээгээр дамжуулан хэрэглэгчид хүргэх үйлчилгээ
2.	Анти Сифон арга хэмжээ / Нийтээр үзэх арга хэмжээ	Anti-siphoning event	Аливаа радио, телевизэд дангаараа онцгой эрхтэйгээр дамжуулах эрх олгохгүйгээр олон нийтэд хүртээмжтэй хүргэхээр тодорхойлсон үндэсний болон тив, дэлхийн томоохон (голдуу спортын) арга хэмжээ. Зарим улсад нийтээр үзэх арга хэмжээг хуульчлан тогтоосон байдаг.
3.	Арилжааны телевиз	Commercial television	Зар сурталчилгааны үйл ажиллагаанаас олсон орлогыг санхүүгийн гол эх үүсвэр болгодог телевиз.
4.	Хадмал тайлбар	Caption	Телевизийн нэвтрүүлгээр гарч байгаа дүрслэлийн дуу, чимээ, авиа, яриаг тухайн агшинд нь дэлгэц дээр текст хэлбэрээр илэрхийлэхийг Хадмал тайлбар нь хаалттай (Closed caption), нээлттэй (Open caption) гэж 2 төрөл байна.
5.	Хаалттай хадмал тайлбар	Closed caption	Дэлгэц дээр гаргах, гаргахгүйг сонгох боломжтой хадмал тайлбар
6.	Нээлттэй хадмал тайлбар	Open caption	Дэлгэц дээр тогтмол гарах хадмал тайлбар

7.	BC-TY (Видео сан төст үйлчилгээ)	Near VoD (Near Video on Demand)	Хэд хэдэн сувгаар богино хугацааны (голдуу 10-20 минут) зайтай, хуваарийн дагуу дамжуулж буй видео контентоос хэрэглэгч сонгон хүлээж байж үздэг видео сувгийн үйлчилгээ. Нэг талт урсгалтай (one way) телевизийн олон суваг дамжуулах (Хиймэл дагуулын, Тоон олон сувгийн зэрэг) сүлжээнд энэ үйлчилгээг үзүүлдэг.
8.	BCY (Видео сангийн үйлчилгээ)	VoD (Video on Demand)	Хэрэглэгч видео (кино эсвэл нэвтрүүлэг зэрэг) контентийг хүссэн цагтаа сонгон үзэх боломжтой үйлчилгээ. Энэ үйлчилгээ нь АйПиТВ болон интернэтийн сүлжээнд суурилсан байдаг. Төлбөр төлөх хэлбэрээс хамаараад aVOD, sVOD, tVOD гэх мэт төрлүүд байна.
9.	BCY-Б (Видео сангийн бүртгэлд суурилсан үйлчилгээ)	S VoD (Subscription Video on Demand)	Хэрэглэгч бүртгүүлээд, сард тодорхой төлбөр төлөх видео сангийн үйлчилгээ.
10.	BCY-3 (Видео сангийн зар сурталчилгаатай үйлчилгээ)	A VoD (Ad based Video on Demand)	Хэрэглэгч видео сонгон үзэхэд төлбөр төлөхгүй, харин видео үзэж байхад нь зар сурталчилгаа үзүүлдэг видео сангийн үйлчилгээ. Үүний жишээ Youtube суваг юм.
11.	BCY-T (Видео сангийн төлбөрт үзэлтийн үйлчилгээ)	T VoD (Transactional Video on Demand)	Видео контент тус бүр нь төлбөртэй байдаг видео сангийн үйлчилгээ. "Pay-per-view" үйлчилгээ ч гэж мөн нэрлэдэг.
12.	ТҮҮ (Төлбөрт үзэлтийн үйлчилгээ)	PPV (Pay-per-view)	Хэрэглэгч тухайн контентод (голдуу урлаг, спортын арга хэмжээ) төлбөр төлж, шууд дамжуулж буй агшинд нь хүлээн авч үзэх үйлчилгээ
13.	Онцгой байдлын зарлан мэдээлэл	Emergency alert message	Хуулийн дагуу радио, телевизээр олон нийтэд шуурхай хүргэх шаардлагатай сэрэмжлүүлэх мэдээлэл.
14.	Дуу авиа бүхий дүрст бүтээл	Audiovisual content	Ямар материаллаг хэлбэрт оруулснаас үл шалтгаалан, техник хэрэгсэл ашиглан бүтээсэн дүрсийг дуу авианы хамт үзүүлэх боломжтой бүтээл.
15.	Дуу авиа бүхий дүрст үйлчилгээ	Audiovisual service	Дэлхийн худалдааны байгууллагын тодорхойлсноор дуу авиа бүхий дүрст үйлчилгээнд хөдөлгөөнт дүрс болон видео хальс бичих, түгээх, хөдөлгөөнт дүрс тусгах (motion picture projection services) үйлчилгээ, радио телевизийн үйлчилгээ, радио телевизийг дамжуулах үйлчилгээ, дуу бичлэгийн студийн үйлчилгээ багтдаг байна.
16.	Заавал дамжуулах телевизийн сувгууд	Must carry channels	Олон суваг дамжуулах үйлчилгээ (ОСДҮ) эрхлэгчийн сүлжээгээр заавал дамжуулахаар үүрэг хүлээлгэж, төрийн байгууллагаас хууль, журмаар тодорхойлсон телевизийн сувгууд.
17.	Зэрэг дамжуулалт	Simulcast	Аливаа нэвтрүүлгийг радио, телевизээр буюу хоёроос дээш дамжуулах орчноор ижил цагт дамжуулж буй үйл явц.
18.	Кабелийн телевиз (CaTV)	Cable television (CATV)	Телевизийн олон сувгийг нэг цэгт төвлөрүүлэн хэрэглэгчийн телевизорт кабелийн холболтоор дамжуулан түгээх систем. Кабелийн телевиз нь телевизийн олон суваг дамжуулах үйлчилгээний (ОСДҮ) нэг төрөл.

19.	Контент	Content	Харилцаа холбооны сүлжээгээр дамжиж буй үг, дуу, тэмдэг, дохио, текст, зураг, график, хөдөлгөөнт дүрс бүхий электрон хэлбэрт хувиргасан мэдээ, мэдээлэл
20.	Контент бэлтгэн нийлүүлэгч	Content provider	Харилцаа холбооны сүлжээгээр дамжуулж үзэгч, сонсогчид хүргэхээр бүтээл туурвидаг хувь хүн, байгууллага. Үүнд төрөл бүрийн кино, нэвтрүүлгийн студиуд хамаарна.
21.	Насны ангилал	Age classification	Телевизийн нэвтрүүлэг үзэх үзэгчдийн насны ялгаагаар тооцсон ангилал. Ялангуяа хүүхэд, залуучуудад үзүүлэхэд тохиромжтой эсэхийг эцэг эхчүүдэд анхааруулах зорилготой бөгөөд дэлгэц дээрх тусгай тэмдэглээгээгээр илэрхийлэгдэнэ.
22.	Насны ангиллын таних тэмдэг	Age classification symbol	Телевизийн нэвтрүүлэг ямар насны үзэгчид тохиромжтой болохыг илэрхийлсэн дүрслэл. Манайд MNS6587:2016 стандартаар тодорхойлсон бий.
23.	Нөхөх үйлчилгээ	Catch-up TV	Телевизийн эфирт дамжуулагдсан, АйПиТВ-ийн видео санд хадгалагдаж буй телевизийн нэвтрүүлгийг үзэх боломжийг хэрэглэгчид олгодог АйПиТВ-ийн нэмэлт үйлчилгээ.
24.	Олон нийтийн радио, телевиз	Public radio and television	Олон нийтийн эрх ашигт үйлчилдэг, ашгийн төлөө бус радио, телевиз. Олон нийтийн радио, телевизийн үйл ажиллагааг хуулиар зохицуулдаг ба улсын төсөв, олон нийтээс авах татаас болон хандиваар санхүүждэг.
25.	Олон суваг дамжуулах үйлчилгээ (ОСДҮ)	Multichannel broadcast service	Телевиз, радиогийн олон сувгийг нэг цэгт төвлөрүүлэн утастай, утасгүй, хиймэл дагуулын сүлжээгээр хэрэглэгчид гэрээний үндсэн дээр хүргэх үйлчилгээ. Энэ үйлчилгээний төрөлд Кабелийн телевиз, АйПиТВ, Хиймэл дагуулын телевиз, Утасгүй олон сувгийн үйлчилгээ (MMDS, DVB-T2)-нүүд багтана.
26.	Олон улсын өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ	International broadcasting services	Хөтөлбөрөө олон улсын хэл дээр дамжуулдаг, гадаад улсын үзэгч, сонсогчид руу чиглэсэн хөтөлбөртэй телевиз, радиогийн үйлчилгээ.
27.	Орон нутгийн телевиз (радио)	Local television (radio)	Тодорхой нутаг орон, бүсийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж, тухайн газрын онцлог, хэрэгцээ шаардлагад тулгуурласан мэдээ, мэдээлэл бэлтгэдэг телевиз эсвэл радио.
28.	ОТТ үйлчилгээ Интернет суурьтай контентийн үйлчилгээ	OTT (Over the Top) service	Нийтийн интернет сүлжээ ашиглаж, телевиз, радиогийн сувгууд болон төрөл бүрийн аудио, видео контентийг сонгон үзэх боломж олгох үйлчилгээ.
29.	Өргөн нэвтрүүлгийн нэвтрүүлэх станц	Broadcasting station	Телевизийн эсвэл радиогийн өргөн нэвтрүүлгийг дамжуулах зориулалттай цогц техник төхөөрөмж.
30.	Өргөн нэвтрүүлгийн телевиз	Free to air TV	Хэрэглэгч тодорхой хамрах хүрээнд хэрэглэгчийн гэрээгүй, төлбөргүйгээр хүлээн авах боломжтой телевизийн үйлчилгээ.
31.	Өргөн нэвтрүүлэг	Broadcasting	Радио, телевизийн хөтөлбөр бэлтгэх болон тэдгээрийг нэгтгэн харилцаа холбооны сүлжээ, төхөөрөмжөөр нэг цэгээс олон нийтэд нэгэн зэрэг хүргэх үйл ажиллагаа

32.	Радио өргөн нэвтрүүлэг	Radio broadcasting	Хөтөлбөрийн дагуу сонсогчид зориулж бэлтгэсэн үг, дуутай агуулгыг радио давтамж ашиглан олон нийтэд хүргэх үйлчилгээ.
33.	Синхрон	Synchronous	Аливаа үйлдлийг нэгэн цаг хугацаанд зэрэг хийхийг хэлэх ба телевизийн салбарын хувьд сурвалжлагын яриаг синхрон гэж нэрлэдэг. Энэ нь телевизийн кадрт гарч байгаа хүний нүүр царайг, яриатай нь зэрэг гаргах шаардлагаас анх үүсчээ.
34.	Сонсогч	Listener (Radio listener)	Радиогийн хөтөлбөрийг тогтмол болон тодорхой цагт, давтамжтай хүлээн авч сонсдог хүн.
35.	Суваг	Channel	Радио, телевизийн хөтөлбөрийг дамжуулах сүлжээний багтаамжийн нэгж
36.	Сувгийн багц	Channel package	Олон суваг дамжуулах үйлчилгээний хэрэглэгчид санал болгодог хэд хэдэн телевизийн сувгуудыг нэгтгэсэн хэлбэр. Ямар сувгуудыг нэгтгэхээс хамаараад үндсэн багц, кино сувгийн багц, гадаад сувгийн багц гэх зэргээр нэрлэсэн байдаг.
37.	Сувгийн нэр	Station ID	Үзэгч, сонсогчдод танигдах зорилгоор нэрлэсэн телевиз, радиогийн товч нэр.
38.	Теле худалдааны суваг	Homeshopping channel	Төрөл бүрийн бараа, бүтээгдэхүүнийг хэрэглэх заавар, зөвлөгөөг тайлбарлан үзүүлж, үзэгчдээс захиалга авч, хүргэх үйлчилгээ үзүүлдэг телевизийн суваг.
39.	Телевиз	Television	Олон нийтэд хүргэх, сурталчлах зорилгоор тусгайлан бэлдсэн тал бүрийн агуулгатай мэдээлэл, контентийг дуу чимээ бүхий хөдөлгөөнт дүрс хэлбэрээр мэдээлэл холбооны төхөөрөмж, сүлжээ ашиглан олон нийтэд дамжуулан хүргэх үйлчилгээ.
40.	Төлбөрт ТВ	Pay television (Pay TV)	Телевизийн олон сувгийн үйлчилгээ авч буй хэрэглэгч нэмэлт төлбөр төлснөөр идэвхижиж, үзэх боломжтой болдог, зар сурталчилгаа дамжуулдаггүй, тодорхой чиглэлд төрөлжсөн (кино, спорт, танин мэдэхүйн зэрэг) телевизийн суваг.
41.	Утасгүй олон сувгийн үйлчилгээ	Wireless multichannel service	Хэрэглэгчид телевизийн олон сувгийг утасгүй (MMDS, DVB-T2 зэрэг) технологи ашиглан дамжуулан хүргэдэг үйлчилгээ.
42.	Ухраах үйлчилгээ	Start-over TV	Телевизээр дамжуулж буй нэвтрүүлгийг гарч дуусаагүй байхад үзэгч зогсоон урагшлуулж, дахин эхнээс нь эсвэл дундаас нь үзэх боломжийг олгосон АйПиТВ үйлчилгээний нэмэлт үйлчилгээ.
43.	Үзэгч	Audience	Телевиз үзэх боломжтой хэсэг, бүлэг хүмүүс. Аудитор гэж бас нэрлэдэг.
44.	Хиймэл дагуулын ТВ	Satellite TV	Телевизийн олон сувгийг хиймэл дагуулын сүлжээ, технологи ашиглан хэрэглэгчид хүргэх үйлчилгээ. Хэрэглэгч тавган антенн ашиглан үйлчилгээг хүлээн авна.
45.	Хөдөлгөөнт ТВ	Mobile TV	Хэрэглэгч зөөвөрлөн авч явах боломжтой, жижиг хэмжээтэй телевизээр эсвэл гар утсаар үзэх боломжтой, тодорхой хамрах хүрээнд тусгай радио давтамжийн зурваст ажилладаг, телевизийн үйлчилгээ.

46.	Хөтөлбөрийн стандарт	Program standards	Хууль эсвэл аливаа зохицуулалтын баримт бичгээр радио, телевизийн нэвтрүүлэг эсвэл хөтөлбөрт тавих шаардлага, хэм хэмжээ.
47.	Хүй олны өргөн нэвтрүүлэг (ХОӨН)	Community broadcasting service	Өөр хоорондоо ямар нэг холбоотой, өөрөөр хэлбэл, үндэсний болон угсаатны цөөнх, эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд гэх мэт хүйн бүлгүүд өөр бусад тодорхой ашиг сонирхол бүхий хэсэг бүлэг хүмүүст үйлчилдэг радио, телевизийн үйлчилгээ (ХОӨН нь ашгийн бус, хүй олон нь өөрөө өмчөө эзэмшиж, захиран зарцуулж, өөрсдийн сайн дурын үндсэн дээр ажиллаж, өөрсдөө удирдан өөрсдөө хянадаг байна. Санхүүжилтийн гол эх үүсвэр нь төсвийн дэмжлэг, хандив, хязгаарлагдмал зар сурталчилгаа байдаг.)
48.	Хэрэглэгч	Subscriber	Олон суваг дамжуулах үйлчилгээ (ОСДҮ) эрхлэгчтэй гэрээ байгуулж, телевизийн сувгуудыг хүлээн авах боломжоор хангагдсаны төлөө төлбөр төлж байгаа хүн, өрх гэр, байгууллага.

2.2. Нэвтрүүлэг, зар сурталчилгаатай холбоотой нэр томъёо

№	Нэр томъёо	Англи үг	Тайлбар
1.	Анги	Episode	Телевизийн цуврал киноны дараалж гарах дугаар.
2.	Арилжаа сурталчилгааны нэвтрүүлэг (Инфомершиал)	Infomercials	Арилжааны зар сурталчилгааг мэдээллээр баяжуулж, дэлгэрүүлэн мэдээлж буй нэвтрүүлгийн хэлбэр. Өөрөөр хэлбэл сурталчилж буй бүтээгдэхүүний ач холбогдол, заавар зэргийг нь үзэгчид тайлбарлан, хэрхэн хэрэглэхийг харуулдаг. Хугацааны хувьд зар сурталчилгааны шторкоос илүү урт, нэвтрүүлэг хэлбэртэй байна. Европын орнуудад телешоппинг (teleshopping) гэж нэрлэдэг. Зөвхөн ийм нэвтрүүлгээр дагнасан телевизийн сувгууд ч байдаг бөгөөд тэдгээрийг Теле худалдааны суваг (Homeshopping) гэж нэрлэдэг.
3.	Арилжааны зар сурталчилгаа	Commercial advertisement	Иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас өөрийн бараа, ажил, үйлчилгээ, төсөл, үйл ажиллагааны зах зээлийн эрэлтийг нэмэгдүүлэх, боломжит хэрэглэгчийн анхаарлыг татах зорилгоор телевиз, радиогоор төлбөртэй, эсвэл түүнтэй дүйцэхүйц нөхцлөөр дамжуулсан зар мэдээлэл.
4.	Баннер	Banner	Телевизийн дэлгэцийн буланд гарах хөдөлгөөнтэй эсвэл хөдөлгөөнгүй график дүрс, текст. Голдуу нэвтрүүлгийн танилцуулга, зар сурталчилгааны зорилгоор ашиглагддаг. Гэхдээ зохицуулалт, журмаар баннер ашиглан сурталчилгаа гаргах хэм хэмжээг зааж өгсөн байдаг.
5.	Блок	Block / break	Үргэлжилсэн тодорхой, хэсэг хугацаа. Голдуу зар сурталчилгааны блок гэдэг утгаар хэрэглэгддэг.
6.	Бүлэг улирал	Season	Телевизийн олон ангит кино эсвэл нэвтрүүлгийн нэг цуврал. Нэг бүлэг дуусаад тодорхой хугацаа өнгөрсний дараа дараагийн бүлэг эхэлдэг.

7.	Бүтээгдэхүүн байршуулалт	Product placement	Бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээний борлуулалтыг нэмэгдүүлэх зорилгоор тухайн бараа бүтээгдэхүүн үйлчилгээний нэр, барааны тэмдэг, үйлдвэрлэгч болон үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагааны мэдээлэл, уриа, лого, бүтээгдэхүүн зэргийг үгэн болон дүрсэн хэлбэрээр телевиз, радиогийн хөтөлбөр дундуур нэвтрүүлсэн (ТВ-ээр бол харуулах, радиогоор бол унших, дурдах) зар сурталчилгааны хэлбэр.
8.	Далд зар сурталчилгаа	Surreptitious advertisement	Агуулга, хэлбэрийн хувьд зар сурталчилгаа гэж шууд ойлгогдохгүй, хэрэглэгчийн ухамсарт шууд бусаар нөлөөлөх зар сурталчилгаа. Монгол улсын Зар сурталчилгааны тухай хуулийн дагуу далд зар сурталчилгаа нь хууль бус зар сурталчилгаанд хамаарах ба далд зар сурталчилгааг захиалах, бүтээх, түгээхийг хориглодог.
9.	Жингл	Jingle	Сурталчилгаанд ашиглагддаг, богино хэмжээний, ихэнхдээ сурталчилгааны уриа ашигласан, сэтгэлд хоногшихуйц дуу, ая.
10.	Зар сурталчилгаа	Advertisement (Ad, Spot, Commercial)	Иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас өөрийн бараа, ажил, үйлчилгээ, төсөл, үйл ажиллагааны зах зээлийн эрэлтийг нэмэгдүүлэх, боломжит хэрэглэгчийн анхаарлыг татах зорилгоор телевиз, радиогоор нийтэд түгээх зар мэдээлэл. Телевизийн зар сурталчилгаа нь богино хэмжээтэй байх ба нэвтрүүлгийн эхлэл, төгсгөлд эсвэл дундуур хэд хэдээр нь багцлан блок хэлбэрээр гаргадаг. Өөрөөр сурталчилгаа, реклам, шторк, спот гэж мөн нэрлэдэг.
11.	Ивээн тэтгэгч	Sponsor	Гэрээний үндсэн дээр радио, телевизийн нэвтрүүлэгт мөнгөн эсвэл мөнгөн бус (оюуны үнэт зүйл, эд хөрөнгө, ажил гүйцэтгэх зэрэг) хандив өргөн өөрийгөө, эсвэл бүтээгдэхүүнээ сурталчлуулж буй хувь хүн эсвэл байгууллага.
12.	Ивээн тэтгэгчийн сурталчилгаа	Billboard	Ивээн тэтгэгчтэй радио, телевизийн нэвтрүүлгийн үеэр (эхэнд эсвэл төгсгөлд голдуу) ивээн тэтгэгчийг зарлах (логог дүрсээр харуулах эсвэл нэрлэн дурдах) мэдээлэл. Ихэвчлэн 10 секундээс хэтрэхгүй, богино хугацаатай байна. (Billboard гэдэг үг гадна самбарын сурталчилгааг мөн илэрхийлдэг.)
13.	Инфотэйнмэнт	Infotainment	Мэдээллийг цэнгээнт буюу хөгжилтэй, анхаарал татахуйц хөнгөн байдлаар үзэгч, сонсогчдын хэрэгцээ шаардлагад нийцүүлэн хүргэх нэвтрүүлгийн хэлбэр. Инфотэйнмэнт нэвтрүүлэг нь эрч хүчтэй хурдан хэмнэл, сонирхолтой өвөрмөц дүрсний өгүүлэмж, сэтгүүлчийн хурц тод зоримог тайлбартай байдгаараа онцлог.
14.	Мэдээ	News	Дотоод, гадаадад болж байгаа нийгмийн амьдралын чухал баримт, үйл явдлын тухай олон нийтэд мэдээлэх мэдээллийн хэлбэр.
15.	Мэдээллийн хөтөлбөр	News programme	Дотоодын цаг үеийн мэдээ, цаг агаарын мэдээ, спортын мэдээ, олон улсын мэдээ зэрэг хэд хэдэн бие даасан мэдээнээс бүтсэн радио, телевизийн цогц нэвтрүүлэг.

16.	Нийгмийн зар сурталчилгаа	Social advertisement Public service advertising	Нийтийн болон улсын эрх ашигт нийцсэн ашиг тустай үйлс, энэ чиглэлээр мэдлэг, мэдээлэл олгохыг дэмжин тэтгэх зорилгоор хийгдсэн, ихэнхдээ хариу төлбөргүйгээр нэвтрүүлэх арилжааны бус сурталчилгаа
17.	Нийлбэр рейтинг (GRP)	Gross rating point (GRP)	Зар сурталчилгааны компанит ажлыг хэмжих үнэлгээний нэгж ба компанит ажлын хүрээнд цацагдсан зар сурталчилгаа бүрийн рейтингийн нийлбэр.
18.	Нөхөөс бичлэг	Filler programming (Interstitial programming)	Телевизийн хөтөлбөрийн цагийн хуваарьт заасан үндсэн нэвтрүүлэг хооронд гарсан цагийг нөхөж оруулдаг зураглал, телевизийн танилцуулга зэрэг богино хэмжээний бичлэг.
19.	Нэвтрүүлгийн товч танилцуулга	Promotion (Promo, Coming up, next content promo)	Дараа нь эсвэл удахгүй гарах эсвэл шинээр нэвтрүүлэхээр төлөвлөж буй радио, телевизийн нэвтрүүлгийг танилцуулсан, ихэвчлэн 15-60 секундын урттай богино аудио эсвэл видео бичлэг. ТВ хөтөлбөрийн зар, Анонс, Нэвтрүүлгийн промо гэж бас нэрлэдэг.
20.	Нэвтрүүлгийн формат	TV format	Зохиогчийн эрхтэй, телевизийн нэвтрүүлгийн бүрэн зохиол. Голдуу реалити, уралдаант шоу төрлийн нэвтрүүлгүүдийн форматууд байдаг бөгөөд түүний албан ёсны эрхийг нь авснаар өөр улсад, өөр зах зээл дээр өөр оролцогчидтойгоор нэвтрүүлгийг хийж, дамжуулдаг. Мөн телевизийн олон ангит киноны форматууд ч байдаг.
21.	Нэвтрүүлэг	Program	Радио, телевизээр шууд болон бичлэгийн хэлбэрээр дамжуулахаар бэлтгэсэн контент, бүтээл. Нэвтрүүлэг нь өөрийн гэсэн нэртэй, олон төрөл, хэлбэртэй байна.
22.	Оргил цаг	Prime time	Үзэгчид хамгийн их телевиз үзэж буй, эсвэл сонсогчид хамгийн их радио сонсож буй хугацаа буюу цагийн интервал. Тухайн газар нутгийн иргэдийн амьдралын онцлог, хэв маягаас хамаарч оргил цаг улс орон бүрт ялгаатай байдаг ч ихэвчлэн оройн 19 - 23 цагт байдаг.
23.	Пиплметр	People meter	Гэр бүлийн түвшинд, гишүүн тус бүрээр телевиз үзэлтийн байдлыг секундын нарийвчлалтай тасралтгүй бүртгэж, боловсруулалт хийх зориулалттай, телевизорт суурилуулдаг судалгааны электрон төхөөрөмж.
24.	Промо суваг	Barker channel	Олон суваг дамжуулах сүлжээний бусад сувгуудаар нь ямар нэвтрүүлгүүд гарч буй талаар буюу нэвтрүүлгийн танилцуулга, киноны трейлер зэргийг тогтмол гаргадаг суваг. Голдуу хамгийн эхний 0 дугаарт байрласан байдаг.
25.	Рейтинг	Rating	Телевиз, радиогийн суваг, нэвтрүүлэг, рекламны үр дүнг үнэлдэг нэгж. Өөрөөр хэлбэл сонгон авсан хугацааны интервалд харгалзах үзэгчийн (эсвэл сонсогчийн) тооны дундаж үзүүлэлт юм. Телевиз, радиогийн рейтингийг мэргэжлийн судалгааны байгууллагууд тогтсон аргачлалаар тооцон гаргадаг.

26.	Реклам	Advertisement	Зар сурталчилгаатай адил утгатай ба "зар сурталчилгаа" тайлбарыг үзнэ үү.
27.	Сурталчилгааны дуу	Advertisement song	Ямар нэг бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээг сурталчлах зорилгоор, захиалгаар хийсэн бүрэн хэмжээний дуу.
28.	Сурталчилгааны нүүр хуудас	Break bumper	Зар сурталчилгаа эхэлж эсвэл дуусч байгааг илэрхийлэх богино видео дүрслэл.
29.	Төрөл жанр	Genre	Нэвтрүүлгийн өөр хоорондоо төстэй, ижил зүй тогтол, нийтлэг шинж чанар, хэв маягийг нь харгалзан хуваасан ангилал. Телевизийн нэвтрүүлгийг мэдээлэл нийтлэлийн, баримтат уран сайхны, зохиомжит уран сайхны гэсэн 3 үндсэн төрөл жанрт хуваадаг байна.
30.	Үгэн зар	Announcement	Өгүүлбэрээр бичсэн эсвэл хөтлөгч унших хэлбэрээр радио телевизээр түгээж буй зар сурталчилгаа.
31.	Үзэгчийн зан төлөв	Audience behaviour	Үзэгч хэзээ, ямар давтамжтайгаар (өдрийн хэдэн цагт, өдөрт хэдэн цаг, долоо хоногийн хэдэн өдөр, аль гаригт зэрэг) ямар телевизийн ямар нэвтрүүлэг үзэж буйг судалгааны аргачлалаар тооцоолсон мэдээлэл. Үзэгчийн зан төлөв нь технологийн хөгжил, амьдралын хэв маягаас хамаарч өөрчлөгдөж байдаг. Үзэгчийн зан төлөвийн мэдээллийг телевиз, зар сурталчилгаа нийлүүлэгчид хэзээ ямар нэвтрүүлэг, сурталчилгаа байршуулахыг төлөвлөхдөө ашигладаг.
32.	Үзэгчийн хувь Үзэгчийн зах зээлд эзлэх хувь	Share, audience share	Тодорхой хугацаанд тухайн телевизийг эсвэл нэвтрүүлгийг хүлээн авч үзсэн үзэгчдийн хувь хэмжээ. Өөрөөр хэлбэл телевиз үзэж байсан үзэгчдийн хэдэн хувь нь тухайн телевизийг эсвэл нэвтрүүлгийг үзсэн болохыг илэрхийлнэ.
33.	Үзэгчийн хүн ам зүйн үзүүлэлт	Demographics (demos)	Үзэгчдийн нас, хүйс, орлого, боловсрол зэрэг мэдээлэл
34.	Үндэсний бүтээл / нэвтрүүлэг, контент	National content	Нэвтрүүлгийг бүтээсэн байршил, уран бүтээлчид, оролцогчид нь тухайн улс оронд ихэнх нь хамаарч байх хууль, зохицуулалтад заасан шаардлагыг хангасан радио, телевизийн бүтээл.
35.	Хамрах хүрээ	Coverage	1. Тухайн радио, телевизийн сувгийг хүлээн авах техникийн боломжтой газар зүйн бүс нутаг (Broadcast coverage area). Радио, телевизийн тусгай зөвшөөрөлд хамрах хүрээ буюу хаана үйл ажиллагаа явуулах эрхтэй болохыг нь зааж өгдөг. 2. Тодорхой нутаг дэвсгэрт радио, телевизийн сувгийг хүлээн авах боломжтой үзэгчийн (хүн эсвэл өрх айл) хувь. (Channel coverage) Телевизийн үзэлтийн судалгааны үр дүнгээр тодорхойлогддог нэгэн төрлийн хэмжигдэхүүн юм.
36.	Холбоос реклам	Adjacency	Сурталчилгааны блокны эхлэл болон төгсгөлийн реклам.
37.	Хууль бус зар сурталчилгаа	Illegal advertisement	Зар сурталчилгааны тухай хуулиар тодорхойлсон зүй бус, бодит байдалд үл нийцсэн, ёс суртахуунд үл нийцсэн, далд шинж чанартай зар сурталчилгаа. [Зар сурталчилгааны тухай хууль]

38.	Хүртээмж	Reach	Тодорхой хугацаанд радио эсвэл телевизийн сувгийг (эсвэл нэвтрүүлгийг эсвэл зар сурталчилгааг) ядаж нэг удаа үзсэн буюу өртсөн үзэгчийн (хүн эсвэл өрх айл) тоо. Телевизийн үзэлтийн судалгаа, зар сурталчилгааны анализ хийхэд ашигладаг.
39.	Хэрэглэгчийн өгөгдөл	Return path data RPD	Олон суваг дамжуулах үйлчилгээ хүлээн авч байгаа хэрэглэгчдийн телевиз үзэлт, хэрэглээний талаарх мэдээлэл бүхий өгөгдөл. Өөрөөр хэлбэл хэрэглэгчийн өгөгдөл гаргах боломжтой хэрэглэгчийн хүлээн авах төхөөрөмж эсвэл өөр хэрэгслээр дамжуулан үзэгчийн телевиз үзэлт, хэрэглээний талаарх мэдээлэл бүхий томоохон дата баазыг бүрдүүлэх боломжтой байдаг.
40.	Цөөн ангит цуврал	Miniseries	Цөөн тооны ангитай цуврал нэвтрүүлэг эсвэл кино.
41.	Шууд үзэлт	Live viewing	Телевизийн эфирээр дамжуулж буй хөтөлбөрийг тухайн цацаж буй агшинд нь шууд хүлээн авч үзсэн үзэгчийн судалгааны мэдээлэл.
42.	Шуурхай мэдээ	Breaking news	Мэдээний сурвалжлагын багаас яаралтай, онцгой, хойшлуулшгүй үйл явдлыг нэвтрүүлгийн дундуур шууд мэдээлэх үйл явц.

2.3. Радио, телевизийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой ерөнхий нэр томъёо

№	Нэр томъёо	Англи үг	Тайлбар
1.	Дуу оруулалт	Voice-over (VO)	Телевизийн нэвтрүүлэг, киноны үндсэн дүрсэн дээр давхар яриа унших, дүрс гарахтай зэрэгцэж телевизийн нэвтрүүлэгч тайлбар унших ажиллагаа
2.	Дууны найруулагч	Sound director	Дуу хөгжим, аялгууны өвөрмөц хэмнэлийг үүсгэх, хөгжмийн бүтээлийн тусламжтайгаар уран сайхны дүрслэлийг бий болгохтой холбоотой ажил ажил эрхэлдэг уран бүтээлч
3.	Дууны оператор	Sound technician	Радио, телевизийн нэвтрүүлгийн бичлэгийн үед дуу чимээний чанарын шаардлага, дууны түвшинг шалган техникийн хяналт тавих үүрэгтэй ажилтан
4.	Жилийн эфирийн цаг	Broadcast hour	Жилийн турш дамжуулсан радио, телевизийн хөтөлбөрийн нийт цаг.
5.	Зураглаач	Cameraman (Operator)	Дүрс бичлэгийн төхөөрөмжийг удирдаж байгаа мэргэжилтэн.
6.	Мэдээний сурвалжлагын баг	Electronic news gathering (ENG)	Студийн гаднаас мэдээ бэлтгэх үүрэгтэй, сурвалжлагч, зураглаач зэрэг 3-4 хүний бүрэлдэхүүнтэй баг.
7.	Найруулагч	Production director	Телевизийн нэвтрүүлэг, киноны зураг авалтын газар, байршил, тайз заслыг сонгох, дүр хуваарилах зэрэг тайз, дэлгэцийн уран бүтээл бүтээх явцыг бүхэлд нь удирдан зохион байгуулах чиг үүрэгтэй уран бүтээлч.
8.	Нэвтрүүлгийн сүлжээ (Телевизийн хөтөлбөр)	Television program (Television schedule)	Радио, телевизийн сувгаар тогтмол үзүүлдэг нэвтрүүлгийн ерөнхий хуваарь. Тухайлбал ажлын өдрийн 16 цагаас хүүхдийн нэвтрүүлэг, 18 цагаас мэдээ, Даваа болон Лхагва гариг

			бүрийн 20 цагаас Ярилцлагын нэвтрүүлэг зэрэг хуваарилсныг хэлнэ. Өөрөөр телевизийн хөтөлбөр (television schedule) гэж нэрлэдэг.
9.	Нэвтрүүлэгч	Anchor, Anchorman, Anchorwoman Newscaster, Newsreader, News anchor	Улс төр, нийгэм, эдийн засаг, урлаг, спортын гэх мэт мэдээ, мэдээлэл болон зар сурталчилгаа зэргийг олон нийтэд уншиж, сонордуулах үүрэгтэй радио, телевизийн ажилтан.
10.	Редакци	Editorial	Радио, телевизийн нэвтрүүлгийг бэлтгэн гаргах ажлыг хариуцдаг уран бүтээлчдийн хамт олон.
11.	Студи	Studio	Төрөл бүрийн нэвтрүүлэг бэлтгэн, бичлэг хийх, боловсруулах, дамжуулах зэрэг телевиз, радиогийн үйлдвэрлэл явуулах цогц тоног төхөөрөмж бүхий зайлшгүй шаардагдах стандарт нөхцлүүдийг хангасан, гадаад орчны нөлөөллөөс тусгаарлагдсан тусгай объект.
12.	Сурвалжлагч	Reporter	Болж буй үйл явдлын талбараас мэдээлэл цуглуулж, боловсруулах үүрэгтэй радио, телевизийн ажилтан.
13.	Титр /Хадмал орчуулга	Subtitle	Дэлгэцийн доогуур текст хэлбэрээр гарах нэвтрүүлэг, кинонд гарсан аливаа яриа, харилцан яриа, дэлгэц дээрх дүрсийн нэмэлт тайлбар, орчуулга болон нэрийн бичиглэл.
14.	Үгэн болон урсдаг мэдээлэл	Lower third (Crawling)	Телевизийн дэлгэцийн доогуур нэмэлт байдлаар хөндлөн гүйлгэн гаргах цаг үеийн үйл явдлын талаарх мэдээний хураангуй, нэвтрүүлэгтэй холбоо барих хаяг, утас, редакцийн гомдол санал хүлээн авах, үзэгчидтэй эргэх холбоо тогтоох зэрэг мэдээлэл. Тухайн улсын зохицуулалтаас хамаарч, зар мэдээллийг урсдаг хэлбэрээр гаргахыг хориглох эсвэл урсах хурд, эзлэх хэмжээ зэргийг зааж өгдөг. Манайд MNS6607:2016 стандарт бий.
15.	Хоногийн эфирийн цаг	Air time	Тухайн нэг өдөрт дамжуулахаар бэлтгэсэн радио, телевизийн хөтөлбөр эсвэл нэвтрүүлгийн нийт хугацаа.
16.	Хоцрогдолтой дамжуулал	Delayed broadcast	Үндэсний хэмжээнд цацагдах цагаас өөр цагт, өөр байршилд телевизийн хөтөлбөрийг тодорхой хугацаагаар хоцроож нэвтрүүлэхийг хэлнэ.
17.	Хөтлөгч	Anchor	Радио, телевизийн нэвтрүүлгийг чиглүүлж, өдөөж, хөгжөөж, залж авч явах үүрэгтэй хүн.
18.	Хөтөлбөр	Program, Program schedule	Радио, телевизийн сувгаар дамжуулахаар цагийн хуваарьт оруулсан нэвтрүүлгийн дараалал.
19.	Хөтөлбөрийн товч танилцуулга	Program promo	Радио, телевизийн сувгаар тухайн өдөрт, эсвэл дараа өдөрт дамжуулах нэвтрүүлгийн дараалал, цагийн хуваарийн товч танилцуулга.

20.	Шууд дамжуулалт Шууд эфир	Live broadcasting	Үйл явдлыг газар дээрээс нь сурвалжлан хугацааны хоцрогдолгүй үзэгч, сонсогчдод хүргэх үйл явц. Студид болон студийн гаднаас шууд дамжуулалт хийх боломжтой. Шууд дамжуулалт нь шууд эфирийг бий болгодог.
21.	Шууд сурвалжлага	Live reporting	Болж буй үйл явдлыг газар дээрээс нь байгаа өнгө төрх, дуу чимээтэйгээр нь үзэгч, сонсогчид мэдээлэн хүргэх ажиллагаа
22.	Эвлүүлэг	Editing	Бичиж авсан дүрснээс тодорхой хэсгийг сонгон шаардлагатай дэс дараалалд оруулж, уг дүрснүүд утга, агуулгын хувьд нийлэн үйл явдал тасралтгүй үргэлжилж буй мэт сэтгэгдэл төрүүлэхийн тулд хийж буй үйлдэл.
23.	Эфир	On air	Радио, телевизийн нэвтрүүлгийг хуваарийн дагуу дамжуулж буй үйл явц. Эфирт дамжуулах нэвтрүүлэг нь урьдчилан бэлтгэсэн эсвэл шууд дамжуулал байдаг.

3.Ном зүй

Олон нийтийн радио телевизийн тухай хууль, 2005 он

Зар сурталчилгааны тухай хууль, 2002 он

Зохиогчийн эрх, түүнд хамаарах эрхийн тухай хууль, 2006 он

Өргөн нэвтрүүлгийн зохицуулалт, нөхцөл шаардлага, ХХЗХ, 2015 он

Өргөн нэвтрүүлгийн үгэн болон урсдаг мэдээллийн форматад тавих шаардлага - MNS6607:2006 стандарт

Өргөн нэвтрүүлэгт насны ангилал тогтоох, таних тэмдэг ашиглах шаардлага – MNS6587:2016 стандарт

Телевизийн сэтгүүл зүй, үндсэн ойлголт, зөвлөмж, ном– Х. Наранжаргал, 2006

Телевизийн тухай А-Я хүртэл (тайлбар толь), ном – Г.Мэндхүү, Т.Өнөрсайхан, 2014

Сэтгүүл зүйн тайлбар толь, ном – М. Зулькафил,

Телевизийн сэтгүүл зүй, түүх, онол практик, сэтгүүл – МУИС, Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхим, 2018 он

The OFCOM broadcasting code

OFCOM Communications Market Report 2018, Methodology & Glossary

The ultimate list of Broadcast journalism terms, New York Film academy, USA

ICA glossary of media terminology: Broadcast & Internet, Institute of Communications and Advertising

Broadcasting Services Act 1992 Australia

Law On Television and Radio Broadcasting, Ukraine

Broadcast Terminology: The Medialink Broadcasting Glossary

Canadian Radio-television and Telecommunications Commission Act

Georgian law on Broadcasting

Глоссарий рекламных терминалов, Эрлинг-рекламно информационное агентство

Глоссарий, Индустриальный Телевизионный Комитет, Украин

Словарь рекламных терминов, Агентство Стимулирования Продаж, Россия